



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2026 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн дүгнэлтийн дагуу Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх “Си чаннель” ХХК-ийн 12900335 тоот тусгай зөвшөөрлийн хугацааг 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2031 оны 08 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасанд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР